e-journal
10th Anniversary
AMCHAM CSR
Дугаар 05, 11-р сар 2021 он

Америкийн Худалдааны Танхимын Нийгмийн Хариуцлагын Хорооноос гаргаж буй цахим сэтгүүл

badrakh energy
GOLOMT BANK Investing for a brighter future
KHAN BANK
Oyu Tolgoi
PETROMATAD
RioTinto
TRANSWEST MONGOLIA LLC

Говьд биологийн олон янз байдлыг хамгаалах шийдэл буюу дүйцүүлэн хамгаалал

Бадрах Энержи" ХХК Дорноговь аймагт Зөөвч-Овоо ураны орд дээр уул уурхайн төсөл хэрэгжүүлж байна. Өнөөдрийн байдлаар газрын доор уусган олборлох технологийн техник, эдийн засгийн үзүүлэлт болон технологиос байгаль орчинд үзүүлэл нөлөө бага болохыг баталгаажуулах зорилгоор Зөөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтыг гүйцэтгэж байна.

Үйлдвэрлэлийн туршилтын барилга угсралтын ажлаас шалтгаалан биологийн төрөл зүйл алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Бадрах Энержи" компани говийн бүсийн ургамлын унаган төрөл зүйл болох заг мод тарьж дүйцүүлэн хамгаалах аргыг сонгоод байна.

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ, УРГАМАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Үйлдвэрлэлийн туршилтын үйл ажиллагаанд өртөх газар нутагтай тэнцүү талбайд (5 га) заг мод дахин тарих нь "Бадрах Энержи" компанид тулгарч буй сорилт юм.

Энэ төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд говь цөлийн хуурай бүсэд мод ургамлын тариалалтаар мэргэшсэн Монголын мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн хорооны туслалцаатай заг модыг тарих талбайг нарийвчлан сонгон авсан. Энэ талбай нь үйлдвэрлэлийн туршилтын талбайд ойр, заг модыг тогтвортой тарьж ургуулах боломжтой буюу мал амьтан ихээр бэлчдэггүй, хүрч очиход хүндрэлгүй, хажуудаа усны эх үүсвэртэй.

Оролцогч талуудын зүгээс уг дүйцүүлэн хамгаалах, ургамалжуулах арга хэмжээг дэмжсэн ба уг ажлыг гүйцэтгэхдээ орон нутгийн ард иргэдийн зан заншил, уламжлалыг онцгойлон хүндэтгэн хэрэгжүүлэхийг сануулсан. Байгаль орчны талаарх хамгийн тогтвортой арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх үүднээс тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн туршлагыг судалж, харьцуулах судалгааг гүйцэтгэсэн. Говь цөлийн хуурай бүсэд мод ургамлын тариалалтаар мэргэшсэн Монголын мэргэжлийн байгууллагуудтай хамтран уг дүйцүүлэн хамгаалах, ургамалжуулах ажлыг хэрэгжүүлнэ.

Үйлдвэрлэлийн туршилтын үед биологийн олон янз байдлыг дүйцүүлэн нөхөн хамгаалах энэ төсөл хэрэгжсэнээр цаашдын үндсэн үйлдвэрлэлд ашиглах цогц шийдлийн мэдлэг, дадлага бий болох юм



ОНЦЛОХ ТОО БАРИМТ: ГОЛ ОГНОО, ТОО БАРИМТ

Мод ургамал тарих 5 га талбай
3000 ширхэг заг мод тарина

2016-2018: Судалгаа, харьцуулах үзүүлэлт болон төслийн төлөвлөлтийг боловсруулав
2020: Мод ургамал тарих талбайг сонгож, мод үржүүлж, үрслүүлэх талбай бэлдэв
2021: Модны суулгацыг тарьж эхлэв

ЦААШИД...

"Бадрах Энержи" ХХК-ийн дийлэнхи хувьцаа эзэмшигч Орано Майнинг компани нь Францын Олон улсын хөгжлийн хөдөө аж ахуйн судалгааны төвтэй хамтран Төв азийн бүс нутгийн Монгол зэрэг улсын хуурай цөл нутгуудад байгаль орчны дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх зарчмыг судалж, туршиж байна. Энэхүү судалгааны ажил нь хүрээлэн буй байгаль орчин, экосистемд дээд зэргээр таарч тохирсон, дасан зохицох төрөл зүйлийг сонгох боломжийг бүрдүүлж байгаа юм.

Голомт Банк

Голомт банкны Алтантүлхүүр хүүхдийн сан “Зүрх мартахгүй” төслийг хоёр дахь жилдээ дэмжин ажиллана

Голомт банкны Алтантүлхүүр хүүхдийн сан “Зүрх мартахгүй” төслийг хоёр дахь жилдээ үргэлжлүүлэн дэмжиж, албан ёсны хамтрагчаар ажиллах санамж бичгийг байгууллаа.

Арга хэмжээнд төслийг санаачлагч “Улаанбаатар Сонгдо” эмнэлгийн ерөнхий захирал Б.Болдсайхан, Голомт банкны ерөнхийлөгч Г.Ганболд нар оролцон хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурснаар Голомт банкны Алтантүлхүүр сан тус төсөлд санхүүгийн болон шаардлагатай бүхий л зүйлсээр дэмжин ажиллахаар боллоо. Төрөлхийн зүрхний гажигтай хүүхэд багачуудыг эх орондоо оношлон мэс засал хийж, бяцхан зүрхнүүдэд амьдрал бэлэглэх зорилготой “Зүрх мартахгүй” төслийг “Улаанбаатар Сонгдо” эмнэлгээс өнгөрсөн оны тавдугаар сард санаачлан хэрэгжүүлж эхэлснээр нийт 170 бяцхан хүүхдэд зүрхний мэс засал хийж, амьдрал бэлэглээд байна. Голомт банкны Алтантүлхүүр хүүхдийн сан нийгмийн хариуцлагын хүрээнд өнгөрсөн жил тус төсөлд 120 сая төгрөг хандивлан 12 хүүхдийн хагалгааны зардлыг бүрэн хариуцсан бөгөөд энэ жилийн хувьд мөн 120 сая төгрөг хандивлан хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхээ илэрхийлсэн юм.

“Зүрх мартахгүй” төслийн багийнхан үйл ажиллагаагаа улам өргөжин тэлж, улирал бүр алслагдсан аймаг сумдад очиж үнэ төлбөргүй үзлэг хийх, мөн 2027 он гэхэд нийт 1,000 хүүхдэд зүрхний мэс засал хийх зорилт тавин ажиллаж байна. Санамж бичиг байгуулах үеэр Голомт банк бусад төрийн болон хувийн хэвшлийн бүхий л аж ахуйн нэгж, байгууллагуудад хандан “Зүрх мартахгүй” төсөлд нэгдэж, бяцхан зүрхнүүдэд амьдрал бэлэглэхийг уриаллаа.

ХААН Банк

ХААН БАНК 30 ЖИЛИЙНХЭЭ ОЙГООР СЭЛБЭ ГОЛЫН ЭХИЙГ ОЙЖУУЛНА

ХААН Банк 2007 оноос эхлэн “ХААН Банкны Ой” мод тарих хөтөлбөр хэрэгжүүлсээр ирсэн билээ. ХААН Банк Сангаар дамжуулан хэрэгжүүлсэн энэхүү хөтөлбөрийн хүрээнд нийт 24 мянган мод тарьж ургуулаад байна.

Үүсгэн байгуулагдсаны түүхт 30 жилийн ойг тохиолдуулан ХААН Банк компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд 5 жилийн хугацаанд Сэлбэ голын эх орчмын 40 гат талбайг ойжуулахаар 2021 оны 10 сарын 09-нд Үндэсний мод тарих өдрийг тохиолдуулан ХААН Банкны ой-2021 мод тарих өдөрлөгийг зохион байгуулж, ХААН Банкны 100 хүртэлх ажилтнууд 500 ширхэг шинэс мод тарьж уг төслөө эхлүүллээ.

Хүний буруу үйл ажиллагаа болон байгалийн хөнөөлд өртөн эргэн ургах чадвараа алдаж ойгүй болсон тус талбайд төслийн хугацаанд нийт 108,000 ширхэг мод тарих ба уг ажлын бэлтгэл өнгөрсөн хавраас эхэлжээ.

Агаарын бохирдлыг багасгахад чухал нөлөө үзүүлдэг шинэс модыг энэ бүсэд тарьснаар ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, Сэлбэ голын эхийн ундаргыг сэргээх, улмаар Сэлбэ голын Туул голд цутгах урсацыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

АмЧам Монгол оюутан залууст зориулсан Ментор өдөрлөгийг тав дахь жилдээ амжилттай зохион байгууллаа

Монгол дахь Америкийн Худалдааны Танхимаас (АмЧам Монгол) цар тахлын үед халдвар хамгааллын дэглэмийг сайтар баримталж тав дахь жилдээ оюутан залууст зориулсан АмЧам Ментор өдөрлөгийг Хаан банк цамхагт амжилттай зохион байгууллаа.

Ментор өдөрлөгт дотоодын их, дээд сургуулиудын 30 оюутан залуус оролцсон бөгөөд бүтэн өдрийн турш Монголын тэргүүлэх бизнесийн манлайлагчдын илтгэлийг сонсож, шилдэг компаниудын хүний нөөцийн мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч ажлын байранд үүсч буй шинэ чиг хандлага, эзэмших шаардлагатай ур чадвар болон өөрсдийн нөөц бололцоогоо хэрхэн бүрэн дүүрэн ашиглан карьераа амжилттай ахиулах талаар олон төрлийн сонирхолтой мэдээлэл сонслоо.

Энэхүү арга хэмжээг АмЧам Монголын ТУЗ-ийн дэд дарга Н. Мөнхнасан нээж хэлсэн үгэндээ АмЧам Монгол нь нийгмийн хариуцлагын хүрээнд энэ өдөрлөгийг уламжлал болгон зохион байгуулж ирсэндээ их баяртай байгаагаа онцлон тэмдэглэж өнөөдрийн өдөрлөгт оролцож буй оюутан залуст цаашдын Ментор өдөрлөгт зочин илтгэгчээр оролцохыг хүсэн ерөөв.

Энэ жилийн Ментор өдөрлөгт АмЧам Монголын гишүүн байгууллагууд болох Ард Санхүүгийн Нэгдэл, Barloworld Mongolia, DB&GTS LLP, Faro Foundation/ Facebook, Наран Мандал, Steppe Group, Хаан банк болон хамтран ажилладаг уламжлалт түнш Монгол дахь АНУ-ын Элчин сайдын яам, TomYo Edtech боловсролын байгууллагын гүйцэтгэх удирдлагууд урилгаар хүрэлцэн ирж бүтэн өдрийн турш илтгэл тавьж, панел хэлэлцүүлэг өрнүүлж, ажил мэргэжлийн амжилтаа хэрхэн эхлүүлсэн туршлагаасаа хуваалцаж, оюутнуудад урам зориг өгөх яриа хийж, сонирхсон асуултад хариулав.

Мөн арга хэмжээнд Mongolian Talent Network, MCS, Хаан банк, TomYo Edtech зэрэг байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүд оролцож өргөдөл, намтраа хэрхэн зөв бичих, ажлын ярилцлагын үеэр ямар ур чадвараа илүү тодотгон ярих талаар практик зөвлөгөө өгч сургалт явуулсан юм.

Өдөрлөгт АНУ-ын Элчин сайдын яам оролцож гадаадад суралцах боломжийн талаар зөвлөгөө өгсөн юм.

АмЧам Монголын энэ жилийн Ментор өдөрлөгийн ерөнхий ивээн тэтгэгчээр Barloworld Mongolia, Herbalife Nutrition болон Хаан банк хамтран ажиллалаа.

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨСӨЛ:

Оюу толгой ХХК ЦЕГ-тай 2019 онд хамтын ажиллагаагаа эхлүүлж, дөрвөн нөлөөллийн аяныг орон даяар амжилттай хэрэгжүүлээд байна. Монгол Улс нэг жилд 500 гаран хүнээ зам тээврийн ослоор алдаж, 5000 орчим хүн гэмтдэг статистик үзүүлэлттэй байдаг. Зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтлийг бууруулах, замын хөдөлгөөний соёлыг бий болгож, олон нийтэд хэвшүүлэх зорилгоор Оюу толгой компани энэхүү хамтын ажиллагааг эхлүүлсэн түүхтэй. 2019 онд "Яараад яахав дээ" аяныг жолооч нарт, "Дураараа биш дүрмээрээ" аяныг хөдөлгөөнд оролцогч бүх хүнд, 2020 онд "Яараад яахав дээ-2" аяныг тээврийн хэрэгслээр зорчиж буй зорчигч нарт, 2021 онд "Ирээдүйгээ хамгаалъя" аяныг хүүхдэд зориулан тус тус зохион байгуулсан. Аяны хүрээнд Чойр, Дархан, Сэлэнгэд дундаж хурд хэмжигч байршуулсан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулсаар байна. 2021 онд гурав дахь буюу Замын-Үүдэд энэхүү хурд хэмжигчийг байршуулахаар ажиллаж байна.

Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан дөрвөн аяны үр дүнд 3 жил дараалан нийт зам тээврийн осол, гэмтэл, нас баралт буурсан үзүүлэлттэй гарлаа. Нийгмийн хариуцлагын үйл ажиллагааныхаа томоохон хэсэг болгож, хүний амь нас, эрүүл мэндтэй холбоотой асуудалд шийдэл гаргахаар төрийн байгууллагатай хамтран манлайлан оролцсон нь хамтын ажиллагааны үлгэр жишээ болж байна.

ИРЭЭДҮЙГЭЭ ХАМГААЛЪЯ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Оюу Толгой

Осол аюулгүй зорчих аянд идэвхтэй оролцсон жолооч, зорчигч та бүхэндээ гүн талархал илэрхийлье!

2019 он — ЯАРААД ЯАХАВ ДЭЭ!

Хотоос хөдөө рүү чиглэсэн хөдөлгөөн: 216,000 | 392,000

НИЙТ ОСОЛ	ГЭМТЭЛ, БЭРТЭЛ	НАС БАРАЛТ
50.8%	49.7%	11.7%
↓ БУУРСАН	↓ БУУРСАН	↓ БУУРСАН

2019 он — ДУРААРАА БИШ ЭЭ! ДҮРМЭЭРЭЭ

НИЙТ ОСОЛ	ГЭМТЭЛ, БЭРТЭЛ	НАС БАРАЛТ
16.3%	22.4%	22.2%
↓ БУУРСАН	↓ БУУРСАН	↓ БУУРСАН

2020 он — ЯАРААД ЯАХАВ ДЭЭ!

Хотоос хөдөө рүү чиглэсэн хөдөлгөөн: 2x ↑ 455,000 | 741,000

НИЙТ ОСОЛ	ГЭМТЭЛ, БЭРТЭЛ	НАС БАРАЛТ
22.4%	26.9%	23.4%
↓ БУУРСАН	↓ БУУРСАН	↓ БУУРСАН

2021 он — ИРЭЭДҮЙГЭЭ ХАМГААЛЪЯ

НИЙТ ОСОЛ 5% БУУРСАН

ГЭМТЭЛ, БЭРТЭЛ	НАС БАРАЛТ	ХҮҮХДИЙН ГЭМТЭЛ, БЭРТЭЛ	ХҮҮХДИЙН НАС БАРАЛТ
25.5%	33.3%	1%	33.3%
↓ БУУРСАН	↓ БУУРСАН	↓ БУУРСАН	↓ БУУРСАН

Аюул ослоос ангид байгаарай!
"Оюу толгой" ХХК

ot.mn OTMongolia OTMongolia Oyu Tolgoi OTMongolia OTMongolia

Петро Матад ХХК

Петро Матад ХХК нь газрын тосны хайгуул болон олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компани юм.

Тус компани 2005 онд байгуулагдаж 2006 онд Монгол Улсын Засгийн Газартай Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/ байгуулан 2008 онд Лондонгийн Хөрөнгийн Биржид элссэнээр 2 дахь зах зээл буюу AIM дээр Монгол улсаас гадаадын хөрөнгийн биржид бүртгэгдсэн анхны компани болсон бөгөөд сүүлийн 3 жилийн хугацаанд Монгол улсад хамгийн идэвхтэй газрын тосны хайгуул хийж байгаа компани юм.

Монголын геологын салбар үүсч хөгжсөний 80 жилийн ойгоор Газрын тосны хайгуулын шилдэг компаниар шалгарсан. Одоогоор тус компани газрын тосны хайгуулын ажилд 100 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийгээд байна.

Монгол улсын 3Г-тай газрын тосны Матад ХХ, Богд IV, Онги V талбайд БХГ байгуулан өөрсдийн санхүүжилтээр хайгуулын ажлаа амжилттай явуулж 2019 онд БХГ-т Матад ХХ талбайд газрын тосны орд илрүүлэн улмаар 2021 оны 7 сард Ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаар газрын тосны хайгуул, олборлолтын компани гэж нэрлэгдэхээр болсон.

Манай компанийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг нь Компанийн нийгмийн хариуцлагын / КНХ / хүрээнд хийгдэж буй хөтөлбөрүүд юм. Бид КНХ-н хөтөлбөрүүдийг хандив, тусламж, богино хугацааны төсөл гэх мэт хязгаарлагдмал хүрээнд бус тухайн орон нутгийн дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, боловсролыг дэмжих, соёлын өвийг хамгаалах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих үндсэн чиглэлүүдээр хэрэгжүүлсээр ирсэн.



ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

ОНГИ V-ТАЛБАЙ / ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

"Инженерийн хийцтэй гүний худаг гаргах" төсөл, Гучин-Ус сум / 96,445,686 сая/ 2018

Тус сумын бэлчээр отрын бүс нутагт бэлчээрийн зориулалттай мал усалгааны худаг хангалттай бус байдгаас зуны улиралд малчид нутаглах боломжгүй. Нутгийн иргэд гүний худаг гаргах оролдлого олон удаа хийж байсан ч хөрсний онцлог болох "Хөвдөг элс"-ний нуралтаас болоод олон худаг ашиглах боломжгүй болсон байсан тул хамгаалах шүүлтүүр бүхий яндан суурилуулсан, насжилт өндөртэй, иж бүрэн гүний худаг гарган нутгийн иргэдэд хүлээлгэж өгсөн.

"Сумын хогийн цэгийг цэвэрлэн тохижуулах төсөл", Гучин-Ус сум / 6,123,930 сая/ 2018

Сумын хогийн талбайг тэлж 2.5 га газрыг хамарсан бөгөөд хавар зундаа гантай байсны улмаас малын үхэл хорогдол ихэсч сэг, зэм замбараагүй хаягдаж байгальд нэлээдгүй сөрөг нөлөө үзүүлсэн байдал нь с умын иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлд маш муугаар нөлөөлөх нөхцөл байдал үүссэн. Хогийн цэгийн орчимд үүссэн малын сэг зэмийг булшлан дарж хогийн цэгийг ландфиллын аргаар засаж цэвэрлэснээр сумын оршин суугчдын эрүүл ахуй, амьдрах орчныг сайжруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

"Авто ачигч машин" төсөл, Гучин-Ус сум /32,000,000/ 2018

Сумын иргэдийн эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд сумын төв дэх 2 га хогийн цэгийг цэвэрхэн байлгах, цас зудтай цаг агаар хүндэрсэн нөхцөлд зам гаргах, цас цэвэрлэх мөн газар шорооны ажилд хэрэглэх зориулалтаар хандивласан.

"Хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах" төсөл, Гучин-Ус сум / 18,260,000 сая/ 2018

Өвөрхангай аймгийн ИТХ-аас 2018 оны хичээлийн жилийг "Хүүхдийн хөгжил, хамгааллын жил" болгосонтой холбоотой Гучин-Ус суманд хэрэгжих хөтөлбөрийг дэмжиж сумын 500 гаруй хүүхэд тоглох хүүхдэд ээлтэй, орчны эрүүл ахуй, аюулгүйн шаардлагыг хангасан, өнгө үзэмж сайтай тоглоомуудыг гадаа тоглоомын талбайд суурилуулж, хүүхдүүд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх нөхцөлийг бүрдүүлсэн.

БОГД IV- ТАЛБАЙ / БАЯНХОНГОР АЙМАГ

"Камержуулах, Гэрэлтүүлэг хийх төсөл" Баацагаан сум / 36,000,000 сая / 2018

Сүүлийн жилүүдэд хөдөөгийн багийн айл өрхүүд сумын төвд сургуульд сурдаг хүүхдүүдтэйгээ хамт амьдрахаар сумын төвд нүүж ирэн хүн амын суурьшил төвлөрөл нэмэгдэж байгаатай холбоотой орон гэр, эд хөрөнгийн хулгай, архидалт, архидан согтуурсны улмаас ард иргэдийн амгалан тайван байдал алдагдах гэх мэтээр гэмт хэрэг, зөрчлийн тоо нэмэгдэж, гэмт хэрэг зөрчлийн илрүүлэлт төдийлөн сайнгүй байсан. Сумын төвд гэрэлтүүлэг хийснээр гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сумын иргэдийн аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлж сумын тохижилт, соёлжилтыг дээшлүүлсэн.

"Хог тээврийн авто машин" төсөл, Баацагаан сум / 50,144,000 сая / 2018

Баацагаан сумын төвд төрийн 6 байгууллага, 7 хоршоо, 17 хүнсний дэлгүүр, 3 цайны газар ажиллаж 285 өрхийн 1140 иргэн амьдардаг. Айл өрх, ААН-үүдээс хоногт дунджаар 2.5 тонн ахуйн хог гардаг ба хог цэвэрлэж тээвэрлэх машин байдаггүй нь сумын иргэдийн тохитой амьдрах нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж, хаврын улиралд халдварт өвчин гарах нөхцөл бүрддэг байна.Тиймээс уг төслийг хэрэгжүүлсэн нь айл өрх, аж ахуйн нэгж, үйлчилгээний газруудын ахуйн хогийг тусгай графикийн дагуу ачиж, хогийн нэгдсэн цэгт тээвэрлэн буулгах болсноор сумын иргэдийн эрүүл амьдрах нөхцөл байдал сайжирсан.

"Сургуулийн дотуур байранд тавилга эд хогшлын туслалцаа үзүүлэх" төсөл, / 11,540,566 сая/ 2018

Баацагаан сумын "Цагаан далай" дунд сургуулийн 14 бүлэгт 337 хүүхэд суралцдаг ба тэдгээрийн 44 нь малчдын хүүхдүүд бөгөөд сургуулийн дотуур байранд амьдардаг. Дотуур байрны тохижилт нь хүүхдүүдийн эрүүл аюулгүй, тав тухтай орчинд амьдрах, сурах эрхийг хязгаарлаж байсан тул шаардлагатай тавилга, эд хогшлыг шинээр авч бэлэглэн тав тухтай, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн.

"Байдраг голын сав дагуу 10 га талбайд ойн зурвас байгуулах" төсөл Баацагаан сум / 21,600,000 сая/ 2018

Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд Бөөнцагаан нуурын цутгалын эх болох Байдраг голын сав дагуух 10 га талбайд ойн зурвас байгуулах нь цөлжилтийг сааруулах, хөрсний эвдрэл, элэгдлийг багасгах, усны ундаргын төвшинг нэмэгдүүлэх байгалийг унаган төрхөөр нь хойч үедээ үлдээх зорилт бүхий хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжиж санхүүжүүлсэн.

Цар тахлын үеэр Монголд оношилгооны цогц 4 PCR лаборатори байгууллаа

Рио Тинто групп "COVID-19" цар тахлын эсрэг 1.7 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжийн "Оношилгоо, зайн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийг НҮБ-ын Хүн амын сан, Оюу Толгой компанитай хамтран амжилттай хэрэгжүүллээ.

2020 оны аравдугаар сараас хэрэгжсэн цар тахалтай тэмцэхэд дэмжлэг үзүүлэх тус төслийн хүрээнд Улаанбаатар хотод Эх, Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, Улсын хоёрдугаар эмнэлэг, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг, Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд нийт дөрвөн газар PCR шинжилгээний цогц лабораторийг байгуулж өгсөн билээ. Эдгээр лаборатори нь "COVID-19" цар тахалтай тэмцэх нийтийн эрүүл мэндийн чадавхыг дээшлүүлэх, бусад халдварт өвчин, түүний дотор ханиад томуу, антибиотикт тэсвэртэй сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчин зэрэг өвчний оношилгоо, эмчилгээнд дэмжлэг үзүүлэх юм.

Түүнчлэн эмчийн үзлэгт тогтмол хамрагдах шаардлагатай хүмүүст чухал шаардлагатай үйлчилгээг тасралтгүй үзүүлэх зорилгоор энэхүү төслөөс өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зайн тусламж үйлчилгээгээр хангав. Энэ үүднээс баг, хорооны эрүүл мэндийн ажилтнуудад нийт 86 таблет, 14 зөөврийн компьютер, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний багц олгожээ.

Жижиг, дунд үйлдвэр, гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр

Рио Тинто Монгол компани цар тахлын үеийн хүндрэл бэрхшээлийг туулж буй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон Инвескор санхүүгийн байгууллагатай хамтран жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр хэрэгжүүлж эхэллээ. 1000 гаруй ажлын байрыг хамгаалж үлдэх зорилготой уг хөтөлбөрийн хүрээнд 280 хүртэл бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг олгох боломжтой аж. Хөтөлбөр нь үндсэндээ эмэгтэйчүүд, өрх толгойлсон эцэг, эхийн эрхэлж буй бизнес, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гарааны бизнес, байгаль орчинд ээлтэй, импортыг орлох үйлдвэрлэл зэрэг нийгмийн чухал зорилтот бүлгүүдэд чиглэнэ. Энэхүү зээлийн хөтөлбөрийн хүрээнд уг хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдэд зориулсан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бизнесийн сургалт явуулах бөгөөд сургалтыг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Европын сэргээн босголт, хөгжлийн банк зэрэг хөгжлийн агентлаг, олон улсын санхүүгийн байгууллагууд удирдан явуулна.

Бизнесийн ёс зүйн төв – Бизнесийн орчныг сайжруулж байна

Рио Тинто Монгол компани Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ), Транспэрэнси Интернэшнл Монгол байгууллагатай хамтран бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг дэмжих зорилготой Бизнесийн ёс зүйн төвийг шинээр байгууллаа. Авлигатай тэмцэх, бизнесийн сайн засаглалын олон улсын стандартыг нутагшуулан хэрэгжүүлэх нь Монголын бизнесийн байгууллагуудад арилжааны таатай боломжуудыг бий болгох, гадаадын шууд хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэр татах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх ач холбогдолтой. Энэхүү түншлэл нь МҮХАҮТ-ын гишүүн байгууллагуудад хэрэглэгч төвтэй, туршлагад тулгуурласан үйлчилгээ үзүүлэх, авлигын эсрэг ёс зүйн тодорхойгүй байдлын эрсдэлийн талаарх тэдний ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилготой юм. Мөн хөтөлбөрийн хүрээнд Рио Тинто Монгол компани тус төвийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхийн дээр ил тод байдал, ёс зүйн дүрэм, тогтвортой байдлын чиглэлээрх дэлхий нийтийн тэргүүн туршлагуудыг үргэлжлүүлэн хуваалцана.

Рио Тинто групп

Гандигийн хүүхдүүд төвийн нийтийн номын сан

Рио Тинто Монгол компани хүүхдийн төлөө Вэлүү сантай хамтран "Гандигийн хүүхдүүд" олон нийтийн номын санг байгууллаа. Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хороонд байрлах тус номын сан нь Ганди сантай хамтран хэрэгжүүлдэг нийгэмд чиглэсэн төслийн нэг хэсэг юм. Тус сан нь 2004 онд Энэтхэгийн далайн цунамигаас амьд үлдсэн Роб Форкан, Пол Форкан нарын үүсгэн байгуулсан олон улсын ТББ юм.

Рио Тинто Монгол компаниас иж бүрэн тохижуулж үйл ажиллагааны зардлыг нь санхүүжүүлсэн юм. Тус олон нийтийн номын сан эмзэг бүлгийн хүүхдүүдэд боловсролын тэгш боломж олгоход дэмжлэг үзүүлж, төрөл бүрийн ном, унших материалаар хангахын зэрэгцээ залуус, насанд хүрэгчид, ахмадуудад зориулсан нийгмийн үйлчилгээ үзүүлнэ. Мөн тус номын сан "Хичээлийн дараах гэрийн даалгаврын тусламж" хөтөлбөр хэрэгжүүлж гэр хорооллын бүх насны сурагчдад мэргэжлийн багшийн дэмжлэг үзүүлэх, интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ажил мэргэжлийн хөгжлийн семинар, нутгийн удирдлагын хөтөлбөрүүдийг дэмжих, олон нийтийн уулзалтуудын гол төв болох зэрэг үйл ажиллагаа явуулна.

Энэхүү шинэ санаачилга Рио Тинто компанийн Монголын нийгэмд хөрөнгө оруулах үүрэг амлалтад тулгуурласан бөгөөд үндэсний хөгжлийн зорилтуудыг дэмжих өргөн хүрээтэй түншлэлийн хөтөлбөрийн нэг хэсэг юм.



Дижитал Хархорум – Монголын соёлын өвийг хамгаалж байна

Монголд чухал ач холбогдолтой соёлын өвийг хамгаалах, тэдгээрийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор Рио Тинто Монгол компани гарааны бизнесийн Дижитал Солюшнс компанитай хамтран 13 дугаар зууны Монголын эзэнт гүрний эртний нийслэл Хархорум хотын дүр төрхийг виртуал байдлаар дахин бүтээлээ. Монгол Улсын Их Сургуулийн багш, оюутнуудын байгуулсан Дижитал Солюшнс компани одоо байгаа болон шинээр олдсон археологийн материалуудыг ашиглан виртуал бодит байдлыг дүрсэлсэн анхны бүтээлээ ийнхүү гаргаснаар Монгол улсын түүх, соёлын өвийг дэмжин сурталчлах чиглэлээр Засгийн газрын гаргаж буй хүчин чармайлтад хувь нэмрээ оруулж байна.

МИСХ-г ивээн тэтгэв

Рио Тинто Монгол компани Цахим үндэстэн 2021 арга хэмжээний үеэр Монголын И-спортын холбооноос (МИСХ) зохион байгуулсан "Номадик Мастерс" олон улсын тэмцээнийг ивээн тэтгэлээ. Сүүлийн жилүүдэд И-спортуудыг мэргэжлийн спорт хэмээн хүлээн зөвшөөрөх болсон.Монгол залуус И-спортын янз бүрийн чиглэлд амжилт гарган цаашид Зүүн Азийн и-спортын төв болох томоохон зорилт тавин ажиллаж байна. Рио Тинто Монгол компани Монгол залуучуудын хүсэл тэмүүллийг дэмжиж буйдаа бахархалтай байна.

Transwest ХХК

Transwest Mongolia ХХК-иас нийгмийн хариуцлага, #Komatsu брэндийн 100 жилийн ойн хүрээнд ЗҮГЭЭР БИТГИЙ ХАЯ!!! аяныг дэмжин БЗД-ийн 12 дугаар хороонд хийгдэх бүтээн байгуулалтын ажилд 30 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийн дэмжин ажиллаж байна. Комацу брендийн албан ёсны дистрибьютер Трансвест Монголиа компани Лантуун Дохио ТББ-ийн "Ид шидийн орон -1 болон 2" төслийг дэмжин ажиллаж байсан түүхтэй бөгөөд тус байгууллагын энэ удаагийн санаачлага болох жишиг хүүхдийн тоглоомын талбай байгуулах төсөлд мөнгөн хандив өгөхөөс гадна байгууллага дээрээ хаягдал гялгар уут цуглуулах аян зарлан гялгар уутаа цуглуулж байна. Бидний энэ хандив хүүхдүүдэд тайван аюулгүй тоглох орчин бэлэглэж байгаад бид туйлын сэтгэл хангалуун байна.

АмЧамын гишүүд